



ЗАМЫН ҮҮДИЙН ЧӨЛӨӨТ БҮСИЙН
ЗАХИРАГЧ И.БАТНАСАН ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017.02.23 № 3/309

танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаархи мэдээлэл

Замын үүдийн чөлөөт бүсийн захирагчийн ажлын албаны удирдлага нь Төсвийн тухай хуулийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Нягтлан бодогчдын олон улсын холбооноос баталсан Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Үндэсний аудитын газраас гаргасан Санхүүгийн аудитын гарын авлагын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, гарын авлагын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь дүн хэмжээ болон илчлэл тодруулгыг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгадаг. Түүнчлэн аудитаар удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн зарчим, хийсэн чухал тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлдэг.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Замын үүдийн чөлөөт бүсийн захирагчийн ажлын албаны 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, бодитой илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ



“ЗАМЫН ҮҮД” ЧӨЛӨӨТ БҮС ЗАА-НЫ 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

АУДИТЫН ТАЙЛАН

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:

Санхүүгийн Аудитын Газрын
дарга, Тэргүүлэх Аудитор:
Ц.Наранчимэг

Утас: 261663

Цахим хаяг:

enkhzayas@audit.gov.mn

Аудитын менежер: Я.Самбууням

Утас: 260512

Цахим хаяг:

Аудитор: Н.Нямдаваа

Утас: 260512

Цахим хаяг:

nyamdavaan@audit.gov.mn

Аудитын компани:

Өлзийт Экаунт Аудит ХХК

Утас: 70130460

Цахим хаяг:

auditulziit@gmail.com

Чингэлтэй дүүрэг 6-р хороо

Бумцэндийн гудамж 65-р байр

1 тоот

2017 оны 2 дугаар сар 16 өдөр

1. Агуулга
2. Аудитын гэрчилгээ
3. Менежментийн захидал
4. Аудит хийгдсэн санхүүгийн тайлан
5. Төсвийн гүйцэтгэлийн тайлан

НЭГ. АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар
7. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
8. Шилэн дансны мэдээлэл
9. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
10. Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар
11. Аудитын явцад илрүүлсэн гол зөрчлүүд, гаргасан шийдлүүд
 - 11.1 Авлагын бүртгэлийн талаар
 - 11.2 Бараа материалын бүртгэлийн талаар
12. Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар
13. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
14. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
15. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
16. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
17. Зөвлөмж
18. Зөрчилгүй санал, дүгнэлт

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.1 Төрийн аудитын тухай хуулийн 15.1.2 дахь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дүгээр зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд “Замын-Үүд” чөлөөт бүс ЗАА-ны 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд /ҮАГ-САГ-2017/64/СТА-ТШЗ/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

“Замын-Үүд” чөлөөт бүс ЗАА-ны 2016 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын баталсан холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

“Замын-Үүд” чөлөөт бүс ЗАА-ны 2016 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2016 оны 11 дүгээр сарын 14 өдрөөс 2017 оны 2 дугаар сарын 7 өдрийн хооронд хийхээр төлөвлөн “Өлзийт экаунт аудит” ХХК-ны аудитын баг хэрэгжүүлэв.

“Замын-Үүд” чөлөөт бүс ЗАА-ны 2016 оны санхүүгийн тайланг хуулийн хугацаанд Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

Өлзийт экаунт аудит ХХК аудитыг 2017 оны 1 дүгээр сарын 23 өдрөөс 2017 оны 2 дугаар сарын 16-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг хуулийн хугацаанд “Замын-Үүд” чөлөөт бүс ЗАА-ны удирдлагад гардуулна.

2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

“Замын-Үүд” чөлөөт бүсийн ЗАА-ны төсвийн захирагч нь Монгол улсын “Төрийн албаны тухай”, “Төсвийн тухай”, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай”, “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай”, “Монгол Улсын Засгийн газрын тухай”, “Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай”, “Чөлөөт бүсийн тухай”, “Улсын бүртгэлийн тухай”, “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай”, “Хот байгуулалтын тухай”, “Барилгын тухай”, “Авто замын тухай”, “Эрчим хүчний тухай”, “Газрын тухай” зэрэг хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

“Замын-Үүд” чөлөөт бүс ЗАА-ны 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт томоохон өөрчлөлт ороогүй байна.

3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

“Замын-Үүд” чөлөөт бүсийн ЗАА-ны Монгол Улсын Их хурлаас улс орны нийгэм, эдийн засгийн хөгжлийг эрчимжүүлэх өндөр техник, технологийг нутагшуулах, хөрөнгө оруулалтын таатай орчныг бий болгож, эдийн засгийг либералчилах зорилгоор 1995 онд “Эдийн засгийн чөлөөт бүсийн үзэл баримтлал”, 2002 онд “Чөлөөт бүсийн тухай хууль”, 2003 онд Замын Үүд эдийн засгийн чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай хуулийг тус тус баталсанаар Замын Үүд чөлөөт бүс ЗАА-ыг байгуулах хууль эрх зүйн орчин бүрдсэн.

Засгийн газрын 2004 оны 45 дугаар тогтоолоор Замын-Үүд эдийн засгийн чөлөөт бүсийн Захирагчийн ажлын алба байгуулагдаж, Үйлдвэр, худалдааны яаманд харьяалагдан ажиллаж байсан бөгөөд Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүн өөрчлөгдөж 2008 онд Монгол Улсын Тэргүүн шадар сайд, 2012 онд Монгол Улсын Шадар сайд, 2012 оны 8 дугаар сард Эдийн Засгийн Хөгжлийн Яаманд харьяалагдаж, 2015 оноос Аж үйлдвэрийн яаманд харьяалагдан үйл ажиллагаагаа явуулж байсан.

2016 оны 8 сард Засгийн газрын бүтэц шинэчлэн батлагдсантай холбогдуулан “Замын-Үүд” чөлөөт бүс нь Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээнд шилжиж, төрийн албаны тасралтгүй үйл ажиллагааг ханган ажиллаж байна.

Монгол Улсын Их Хурлын 2004 оны 17 дугаар тогтоолоор Замын Үүд эдийн засгийн чөлөөт бүсийг байгуулахаар шийдвэрлэж, нутаг дэвсгэрийн хэмжээг 900-га-гаар тогтоон хилийн заагийг тодорхойлсон.

Замын Үүд чөлөөт бүсэд тулгамдаж буй асуудлууд, тэдгээрийн дотор тус бүсийн дэд бүтцийн хэрэгцээ шаардлагыг хангах зорилгоор 2008 онд Замын Үүд эдийн засгийн чөлөөт бүсийн дэд бүтцийг сайжруулах төслийг бүсийн Захирагчийн ажлын албанаас санаачлан боловсруулж, Засгийн газраас өгсөн чиглэлийг дагуу төслийн үр өгөөжийг улам нэмэгдүүлэх зорилгоор Замын Үүдийн дэд бүтцийг сайжруулах төсөл болгон техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулан батлуулсан.

Замын Үүдийн дэд бүтцийг сайжруулах төслийн өртөг 58,8 сая ам доллар бөгөөд Монгол Улс, БНХАУ-ын Засгийн газрын хооронд байгуулсан Зээлийн ерөнхий хэлэлцээрт заасны дагуу энэхүү төслийн 50 сая ам.долларыг БНХАУ-ын Эксим банкнаас, 8,8 сая ам.долларыг Монгол Улсын Засгийн газраас санхүүжүүлэн бүтээн байгуулалт өрнөж байна.Төслийн хүрээнд дулаан, цахилгаан, усан хангамж, ариутгах татуурга, авто зам холбооны 4 багц ажлыг гүйцэтгэгч China Camc Engineering ХХК түлхүүр гардуулах нөхцөлтэйгөөр гүйцэтгэж байна.

“Замын-Үүд” чөлөөт бүс ЗАА-ны 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар “Замын-Үүд” чөлөөт бүс ЗАА-ны 2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 12-г гүйцэтгэв.

“Замын-Үүд” чөлөөт бүс ЗАА-ны нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинээр боловсруулан өөрийн үйл ажиллагаанд мөрдөн ажиллаж байна.

“Замын-Үүд” чөлөөт бүс ЗАА-ны санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн Веница програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

5. Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг төлөвлөсөн горимын дагуу сорьсон.

Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд “Замын-Үүд” чөлөөт бүс ЗАА-ны дотоод хяналтын системийг эрсдэл бага гэж тооцсон болно.

Эрсдэлийг бага гэж тодорхойлсон үндэслэл нь төлөвлөлтийн шатанд авсан шалгах хуудас, санал асуулгын дүнд үндэслэсэн бөгөөд дотоод хяналтын гол анхаарах асуудал нь нягтлан бодох бүртгэл, санхүүгийн ажилтнуудын ажлын ачаалал, ур чадвар нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь өөрийн үйл ажилагаанд нь хэр нийцтэй эсэхийг магадлах явдал байв.

6. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогын дүнг сонгов.

Нийт орлогын 1 хувь 7,072.2 мянган төгрөг ба санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардалын болон нийт орлогын дүнгийн 1 хувь нь бараг адил байсан ба бусад үзүүлэлтээр сонгоход материалын түвшин өндөр гарч байгаа тул сонгосонгүй.

7. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар

2016 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавиж ажилласан байна.

“Замын-Үүд” чөлөөт бүс ЗАА-ны 2016 оны орлогын төлөвлөгөөний биелэлтийг дараах хүснэгтээр үзүүлэв.

Төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт

/Мянган төгрөгөөр/

Орлогын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө сарьцуулснаар
Улсын төсвийн санхүүжилт	522,983,6	522,983,6	0.0
Үндсэн үйл ажиллагааны орлого		184,239,5	184,239,5
НИЙТ	522,983,6	707,223,1	184,239,5

Төсвийн зарлагын гүйцэтгэлийг дараах хүснэгтээр үзүүлэв.

/Мянган төгрөгөөр/

Зардлын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэмнэлт + Хэтрэлт -
Цалин хөлс, нэмэгдэл, НДШ	350,664,4	276,883,6	73,780,7
Тогтмол зардал	47,815,4	47,798,3	17,1
Бусад зардал	133,746,6	128,788.0	4,958,6
НИЙТ	522,983,6	444,244,2	78,756,4

“Замын-Үүд” чөлөөт бүсийн ЗАА-ны 2016 оны төсвийн гүйцэтгэлийн тайланг хавсралтаар үзүүлэв.

8. Шилэн дансны мэдээлэл

Энэ ажлын хүрээнд байгууллагын төсөв, хагас, бүтэн жилийн баталгаажсан санхүүгийн тайлан баланс, аудитын дүгнэлт, сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, өр авлагын мэдээ, төлбөрт үйлчилгээний үнэ тариф, журам зааварыг нээлттэй ил тодоор мэдээлж ирсэн байна.

Мөн тухайн тайлант оны худалдан авах төлөвлөгөө нь олон нийтийн хэрэгсэлээр ил тод мэдээлсэн байна.

9. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 10 эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 12 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

“Замын-Үүд” чөлөөт бүс ЗАА-ны 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

Горим сорил хэрэгжүүлэхэд явцад бий болсон төрийн сангийн хөрөнгө оруулалтын дансаар хийгдсэн 390,400.0 мянган төгрөгийн гүйлгээг санхүүгийн тайланд тусгаагүй, харилцагч байгууллага тус бүрийн тооцооны дэлгэрэнгүй бүртгэл хөтлөөгүй, орлого зөв хувиарлаагүй, ашиглагдаагүй биет бус хөрөнгөнд элэгдэл байгуулсан нь УСНББОУС 17-д “байгуулж буй элэгдэл нь байгууллагын хөрөнгийн эдийн засгийн өгөөж буюу үйлчилгээний чадавхийг тусгасан байх ёстой” гэж заасныг, найдваргүй авлага үүсэх, орлогын тайлан буруу илэрхийлэгдэх, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн дансны зааврын 4.49-т “Биет бус хөрөнгийн элэгдлийг түүний үр ашигтай ашиглах хугацааны туршид системтэйгээр хорогдуулж, хорогдлын хэмжээгээр зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэнэ” гэж заасантай нийцэхгүй байна.

10. Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар:

“Замын-Үүд” чөлөөт бүсийн ЗАА-ны 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүний бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн дүнтэй дансанд гарсан ажил гүйлгээг, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа.

Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь тус байгууллагын нийт орлогын 95 хувь, нийт зардлын 90 хувийг тус тус эзэлж байна.

11. Аудитын явцад илрүүлсэн гол зөрчлүүд, гаргасан шийдлүүд:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг 1, материаллаг бус 3 нийт 4 алдаа илэрсэн байна. Үүнд:

Хөрөнгө оруулалтын бүртгэлийн талаар

Тайлант онд Төрийн сангийн 900009310 дугаар хөрөнгө оруулалтын дансаар хийгдсэн 390, 400.0 мянган төгрөгийн гүйлгээ хийгдсэнийг санхүү байдлын, үр дүнгийн, өмчийн өөрчлөлтийн, мөнгөн гүйлгээний болон төсөвийн гүйцэтгэлийн тайландаа тусгаагүй байна.

Энэ ажил нь нийт 780, 806.8 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй Замын үүдийн дэд бүтцийн байгууламжийн ажлын зураг төслийг боловсруулах ажлын багц-1 буюу Дулаан хангамж, цахилгаан хангамж, усан хангамж, ариутгах татуургын зураг төсөв боловсруулах ажил юм байна. Бидэнд мэдэгдэж байгаагаар энэ ажил нь 2013 онд гэрээ нь байгуулагдаж, ажил хүлээлцсэн бөгөөд Аж үйлдвэрийн яаман дээр хэрэгжиж үлдэгдэл төлбөр 390,400.0 мянган төгрөгийг Засгийн газраас вексель бичиж өгсөн. Векселийг 2016 оны 10 дугаар сард төлж барагдуулжээ.

Шийдвэрлэсэн нь:

Төрийн сангийн 900009310 дугаар хөрөнгө оруулалтын дансаар хийгдсэн Зураг төсвийн үнэ 390,400.0 мянган төгрөгийн хөрөнгө оруулалтыг бүртгэж аудитын хугацаанд залруулсан.

“Замын-Үүд” чөлөөт бүс ЗАА-ны 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

Урьдчилж орсон орлогын бүртгэлийн талаар

Газар эзэмшигч харилцагч байгууллагуудтай хийх тооцооны дэлгэрэнгүй бүртгэл хөтлөөгүйгээс Тэс петролиум ХХК-аас орж ирсэн /5 дахь жилийн дараа төлөх ёстой/ газар ашигласны төлбөр 1,050.0 мянган төгрөгийг тайлант хугацааны орлогод бүртгэсэн нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн дансны зааврын 4.63-т “Ажил үйлчилгээг гүйцэтгэж хүлээлгэн өгөх, бараа бүтээгдэхүүнийг нийлүүлэхээс өмнө үнийг нь урьдчилан авсан тохиолдолд урьдчилж орсон орлого дансанд бүртгэнэ” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Аудитын хугацаанд Санхүүгийн тайланд залруулсан бөгөөд цаашид харилцагч байгууллагуудтай дэлгэрэнгүй бүртгэл хөтлөж, урьдчилж орсон орлого дансанд бүртгэж байхыг менежментийн захидлаар зөвлөв.

Биет бус хөрөнгийн бүртгэлийн талаар

2014 онд “Чойр” Эдийн засгийн чөлөөт бүсээс 249,000.00 мянган төгрөгийн үнэ бүхий барилга байгууламж, терминалын зураг төсөл шилжүүлэн хүлээн авч биет бус хөрөнгийн дансанд бүртгэсэн бөгөөд барилга байгууламж нь одоогоор ашиглалтанд ороогүй болно. Гэтэл тус байгууллага нь ашиглагдаагүй байгаа биет бус хөрөнгө зураг төсөлдөө тайлант онд нийт 12,450.0 мянган төгрөгийн элэгдэл тооцсон.

Энэ нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн дансны зааврын 4.49 дүгээрт биет бус хөрөнгийн элэгдлийг түүний үр ашигтай ашиглах хугацааны туршид системтэйгээр хорогдуулж, хорогдлын хэмжээгээр зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэнэ гэж заасныг зөрчсөн байна. Мөн УСНББОУС 17-д элэгдэл тооцохдоо “байгууллагад зарцуулагдах хөрөнгийн эдийн засгийн өгөөж буюу үйлчилгээний чадавхийг тусгасан байх ёстой” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Тайлант оны биет бус хөрөнгийн элэгдлийн зардлыг 12,450.0 мянган төгрөгөөр бууруулан санхүүгийн тайланг залруулах талаар зөвлөмж өгсөн боловч тайлант хугацаанд залруулаагүй.

Худалдан авах ажиллагааны талаар

Тайлант онд 23839,5 мянган төгрөгийн компьютер техник хэрэгсэл худалдан авахдаа “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 33 дугаар зүйлд заасны дагуу харьцуулалтын арга хэрэглэлгүй шууд худалдан авалт хийсэн байна.

Шийдвэрлэсэн нь:

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах хуулийн босго үнэ болон худалдан авалт хийхдээ хэрэглэх аргуудыг зөв сонгохыг зөвлөв.

12. Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар

Аудитын явцад тайлангийн алдааг санхүүгийн тайланд залруулсан боловч 12,450.0 мянган төгрөгийн залруулаагүй алдаа үлдсэн болно.

13. Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Анхаарал татахуйц бусад чухал асуудлууд байхгүй болно.

14. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

2013 онд Эдийн засгийн хөгжлийн яам, Худалдан авах ажиллагааны газар, “Хот төлөвлөлтийн хүрээлэн” ХХК-ны хамтарсан ХААГ-3-2012/ХХII-5 тоот нийт 780,806.8 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй “Замын үүдийн дэд бүтцийн байгууламжийн ажлын зураг төслийг боловсруулах ажлын багц-1 буюу Дулаан хангамж, цахилгаан хангамж, усан хангамж, ариутгах татуургын зураг төсөв” боловсруулах гэрээг байгуулжээ.

МУ-ын Их Хурлын 2015 оны 7 дугаар сарын 282 дугаар тогтоолын дагуу Улсын төсвөөс дутуу санхүүжүүлэгдсэн төсөл арга хэмжээний төлбөрийг Сангийн Яамнаас вексель гарган санхүүжүүлнэ гэж заасны дагуу дээрх зураг төслийн ажлын дутуу төлбөр 390,400.0 мянган төгрөгөнд вексель бичиж санхүүжүүлсэн. Энэхүү векселийн төлбөрийн гүйлгээг Сангийн Яам 2016 оны 10 дугаар сарын 3-нд “Замын-Үүд” чөлөөт бүсийн 900009310 тоот хөрөнгө оруулалтын түр дансаар оруулан Төрийн сангийн 900080001 тоот дансанд шилжүүлсэн боловч дээрх ажил гүйлгээг “Замын-Үүд” чөлөөт бүсийн ЗАА нь тайлант оны санхүүгийн тайландаа тусгаагүй байсныг тусгуулсан. Нийт төсөвт өртөг 780,806.8 мянган төгрөгөөр биш тайлант онд төлсөн 390,400.0 дүнгээр бүртгэсэн.

“Замын-Үүд” чөлөөт бүсийн ЗАА-ны 2016 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй өөр асуудал байхгүй.

15. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

“Замын-Үүд” чөлөөт бүсийн ЗАА-ны 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар 4 асуудал хөндөгдөж нийт 427,800.0 мянган төгрөгийн зөрчил илрүүлсэн. Үүнээс 12,450.0 мянган төгрөгийн зөрчил залруулаагүй, 23,900.0 мянган төгрөгийн зөрчлийг залруулах боломжгүй, 391,450.0 мянган төгрөгийн зөрчлийг тайлант хугацаанд залруулсан болно.

16. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

“Замын-Үүд” чөлөөт бүсийн ЗАА-ны 2015 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар “Зөрчилгүй” санал дүгнэлт авсан бөгөөд аудитын байгууллагаас өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй болно.

Зөвлөмжийн биелэлтийн тайлбарыг тайлангийн хавсралтаар үзүүлэв.

17. Зөрчилгүй санал дүгнэлт

“Замын-Үүд” чөлөөт бүсийн ЗАА-ны 2016 оны 12 дугаар сарын 31 өдрийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн шударга илэрхийлэгдсэн байна.



YAG
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

ЗАМЫН ҮҮД ЧӨЛӨӨТ БҮСИЙН ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБА

Менежментийн захидал

Агуулга

Тэргүүлэх ач холбогдолын дарааллаар жагсаав:

Асуудал 1

Хөрөнгө оруулалтын бүртгэлийн талаар

Асуудал 2

Урьдчилж орсон орлогын бүртгэлийн талаар

Асуудал 3

Биет бус хөрөнгийн элэгдлийн бүртгэлийн талаар

Асуудал 4

Худалдан авах ажиллагааны талаар

Менежментийн захидлын тайлбар, тодруулга:

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Замын үүд чөлөөт бүсийн захирагчийн ажлын албаны удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмж өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Замын үүд чөлөөт бүсийн захирагчийн ажлын албаны удирдлага, санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Асуудал 1 Хөрөнгө оруулалтын бүртгэлийн талаар	Тэргүүлэх ач холбогдол №1
---	----------------------------------

Ажиглалт

Төрийн сангийн 900009310 дугаар хөрөнгө оруулалтын дансаар хийгдсэн нийт 780,806.8 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй Замын үүдийн дэд бүтцийн байгууламжийн ажлын зураг төслийг боловсруулах ажлын багц-1 буюу Дулаан хангамж, цахилгаан хангамж, усан хангамж, ариутгах татуургын зураг төсөв боловсруулах ажлын үнэ 390,400.0 мянган төгрөгийн гүйлгээ 2016 оны 10 дугаар сарын 3 өдөр хийгдсэнийг санхүүгийн тайлан нягтлан бодох бүртгэлдээ тусгаагүй байна.

Зөвлөмж

Зураг төсвийн үнэ 390,400.мянган төгрөгийн хөрөнгө оруулалтыг бүртгэж санхүүгийн тайланд тусгах

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, үнэн зөв, илэрхийлсэн байх батламж мэдэгдэл зөрчигдөх.

Үйлчлүүлэгчийн хариу

Санхүүгийн тайланд өөрчлөлт оруулан урьдчилж орсон орлогын дансандаа л бүртгэж чадна.

Асуудал 2 Урьдчилж орсон орлогын бүртгэлийн талаар	Тэргүүлэх ач холбогдол №2
---	----------------------------------

Ажиглалт

Төрийн сангийн 9000036011 дугаар дансанд 2016 оны 11 сарын 9 өдрийн 1,050.0 мянган төгрөгийн Тэс петролиум ХХК-аас газрын төлбөр гэсэн гүйлгээний утгатай орлого нь 5 жилийн дараа төлөх ёстой газар ашигласны жилийн төлбөрийг тайлант хугацааны орлого гэж бүртгэсэн нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн дансны зааврын 4.63-т “Ажил үйлчилгээг гүйцэтгэж хүлээлгэн өгөх, бараа бүтээгдэхүүнийг нийлүүлэхээс өмнө үнийг нь урьдчилан авсан тохиолдолд урьдчилж орсон орлого дансанд бүртгэнэ” гэж заасантай нийцэхгүй байна.

Зөвлөмж

Урьдчилж орсон орлого дансанд бүртгэж, харилцагч тус бүрээр дэлгэрэнгүй бүртгэл хөтлөн тооцоо нийлж ажиллахыг зөвлөв.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, үнэн зөв, илэрхийлсэн байх батламж мэдэгдэл зөрчигдөх. Найдваргүй авлага үүсэх эрсдэл үүсч байна.

Үйлчлүүлэгчийн хариу

Санхүүгийн тайланд өөрчлөлт оруулан урьдчилж орсон орлого дансанд бүртгэнэ.

Асуудал 3 Худалдан авах ажиллагааны талаар	Тэргүүлэх ач холбогдол №2
---	----------------------------------

Ажиглалт

Тайлант онд 23,839.5 мянган төгрөгийн компьютер техник хэрэгсэл худалдан авахдаа “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 33 дугаар зүйлд заасны дагуу харьцуулалтын арга хэрэглэлгүй шууд худалдан авалт хийсэн.

Зөвлөмж

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авахдаа хуулийн босго үнэ болон худалдан авах аргуудыг хуульд нийцүүлэхийг зөвлөв.

Эрсдэлүүд

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах хууль хэрэгжихгүй байх.

Үйлчлүүлэгчийн хариу

Цаашид зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Асуудал 4 Биет бус хөрөнгийн бүртгэлийн талаар	Тэргүүлэх ач холбогдол №2
---	----------------------------------

Ажиглалт

Тус байгууллага нь ашиглагдаагүй байгаа үндсэн хөрөнгийн зураг төсөлдөө тайлант онд нийт 12,450.0 мянган төгрөгийн элэгдэл тооцсон.

Зөвлөмж

Тайлант оны биет бус хөрөнгийн элэгдлийн зардалыг 12,450.0 мянган төгрөгөөр бууруулан санхүүгийн тайланг залруулах.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлангийн талаарх үнэн зөв байх батламж мэдэгдэл зөрчигдөх мөн тайлант хугацаанд элэгдлийн зардал илүү тусгагдах

Үйлчлүүлэгчийн хариу

Залруулах боломжгүй манай програм хангамж бүх биет бус болон биет хөрөнгөнд элэгдэл тооцдог бөгөөд нөгөө талаар “Чойр”Эдийн засгийн чөлөөт бүсээс шилжүүлэн авахад элэгдэл тооцсон байсан тул засахгүй.

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тайлант үе: 2016/01/01 - 2016/12/31

/төгрөгөөр/

Данс ны код	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ		
	Мөнгөн хөрөнгө	-	-
	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	
	Төсвийн харилцах		
	Нэмэлт санхүүжилтийн харилцах		
	Харилцах / арилжааны /		
	Авлага	-	-
	Төлбөрт үйлчилгээний авлага		
	Татаас санхүүжилтийн авлага		
	Байгуулагасс авах авлага		
	НДШ-ийн авлага өглөг		
	Шатахууны карт /Хувь хүнээс /		
	Цалингийн урьдчилгаа		
	Урьдчилж төлсөн төлбөр	65,792.77	65,789.31
	Урьдчилгаа тооцоо		
	Урьдчилж гарсан зардал	65,792.77	65,789.31
	Бараа материал	4,986,893.11	5,646,219.99
	Бэлэн бүтээгдэхүүн		
	Тусгай зориулалттай материал		
	Хангамжийн материал	4,986,893.11	5,646,219.99
	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	5,052,685.88	5,712,009.30
	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ		
	Үндсэн хөрөнгө		
	Биет хөрөнгө	2,700,707,045.62	3,013,835,259.09
	Барилга байгууламж	2,789,466,475.00	2,789,466,475.00
	Хуримтлагдсан элэгдэл	- 497,270,470.18	- 583,978,932.10
	Авто тээврийн хэрэгсэл	81,821,435.16	67,814,635.16
	Хуримтлагдсан элэгдэл	- 81,821,435.16	- 67,814,635.16
	Машин тоног төхөөрөмж	102,659,586.54	126,499,106.54
	Хуримтлагдсан элэгдэл	- 75,558,206.47	- 89,107,850.67
	Тавилга эд хогшил	21,879,006.77	21,879,006.77
	Хуримтлагдсан элэгдэл	- 20,404,805.04	- 21,258,005.45
	Дуусаагүй барилга	379,935,459.00	770,335,459.00
	Программ хангамж	3,287,000.00	3,287,000.00
	Хуримтлагдсан элэгдэл	- 2,712,937.27	- 3,172,187.23
	Бусад	569,000,000.00	569,000,000.00
	Хуримтлагдсан элэгдэл	- 235,412,500.28	- 279,862,500.32
	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,034,868,608.07	3,303,087,571.54
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	3,039,921,293.95	3,308,799,580.84
	Богино хугацаат өр төлбөр		
	Өглөг	270,000.00	-
	Ажиллагчидтай холбогдсон өглөг	270,000.00	
	Урьдчилж орсон орлого		391,450,000.00
	Богино хугацаат өр төлбөрийн дүн	270,000.00	391,450,000.00
	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	270,000.00	391,450,000.00
	Цэвэр хөрөнгө өмч		
	Засгийн газрын хувь оролцоо	1,350,902,876.02	1,350,902,876.02
	Өмнөх үеийн үр дүн	1,677,173,036.78	1,677,173,036.78
	Тайлант үеийн үр дүн		- 122,301,713.11
	Дахин үнэлгээний зөрүү	11,575,381.15	11,575,381.15
	Цэвэр хөрөнгө өмчийн дүн	3,039,651,293.95	2,917,349,580.84
	ӨР ТӨЛБӨР ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,039,921,293.95	3,308,799,580.84

-

0.00

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Тайлант үе: 2016/01/01 - 2016/12/31

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО		
	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	557,664,635.00	706,173,100.00
	Улсын төсвөөс санхүүжих	414,541,570.00	522,983,600.00
	Урсгал	414,541,570.00	522,983,600.00
	Бусад төсөвт байгууллагаас	-	-
	Нэмэлт санхүүжилтийн орлого	143,123,065.00	183,189,500.00
	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс		
	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан		
	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны		
	Төсвийн урамшуулал		
	Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого	143,123,065.00	183,189,500.00
	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО	-	-
	Үйл ажиллагааны орлогын дүн		
	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	557,664,635.00	706,173,100.00
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ		
	АЖИЛЧИДТАЙ ХОЛБОГДСОН ЗАРДАЛ	282,066,071.00	315,456,239.00
	Цалин хөлс нэмэгдэл урамшил	253,793,029.98	276,883,639.00
	Үндсэн ба нэмэгдэл цалин	253,793,029.98	246,576,439.00
	Хоол унааны хөнгөлөлт		30,307,200.00
	Үр дүнгийн урамшил		
	Нийгмийн хамгааллын шимтгэл	28,273,041.02	38,572,600.00
	Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	23,396,935.88	31,559,400.00
	Тэтгэвэрийн даатгалын шимтгэл		24,546,200.00
	Тэтгэмжийн даатгалын шимтгэл		2,805,300.00
	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл		3,506,600.00
	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл		701,300.00
	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	4,876,105.14	7,013,200.00
	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ УРСГАЛ ЗАРДАЛ	397,694,387.77	513,018,574.11
	Тогтмол зардал	35,071,048.00	47,798,283.00
	Гэрэл цахилгааны зардал	24,889,048.00	43,639,283.00
	Түлш халаалтын зардал	4,836,000.00	
	Цэвэр бохир усны зардал	5,346,000.00	4,159,000.00
	Хангамж, бараа материалын зардал	7,545,806.55	9,062,981.12
	Бичиг хэргийн материал	3,160,025.55	2,193,923.12
	Тээвэр шатахууны зардал	1,472,000.00	3,422,000.00
	Шуудан холбооны зардал	2,913,781.00	3,447,058.00
	Ном хэвлэлийн зардал		
	БҮТЭЭЗүйл		
	Хог устгал цэвэрлэгээ		-
	Норматив зардал	-	-
	Хоол		
	Эм		
	Зөөлөн эд нормын хувцас авах зардал		
	Эд хогшил урсгал засварын зардал	9,910,400.00	9,901,832.00
	Багаж техник хэрэгсэл		
	Тавилга		
	Хөдөлмөр хамгааллын зардал		
	Урсгал засвар	9,910,400.00	9,901,832.00
	Томилолт	7,903,380.00	6,286,160.00
	Дотоод томилолтын зардал	5,800,310.00	6,286,160.00
	Гадаад албан томилолт	2,103,070.00	

	Бусдаар гүйцэтгүүлсэн АҮ төлбөр	22,696,360.00	25,129,700.00
	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил		
	Төрийн өмнөөс гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний төлбөр	20,696,360.00	21,487,700.00
	Аудит		
	Даатгалын үйлчилгээний төлбөр		
	Тээврийн хэрэгсэлийн татвар		
	Тээврийн хэрэгсэлийн оношилгоо		
	Мэдээлэл технолгийн үйлчилгээ		1,642,000.00
	Харуул хамгаалалтын зардал		
	Мэдээлэл сурталчилгааны зардал		
	Аудит, зэрэглэл тогтоох үйлчилгээ	2,000,000.00	2,000,000.00
	Газрын төлбөр		
	Бараа үйлчилгээний бусад зардал	127,611,422.22	147,556,809.99
	Бусад зардал		1,036,253.46
	Хичээл үйлдвэрлэлийн дадлага		500,000.00
	Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал	126,763,762.22	146,020,556.53
	Төлбөр, хураамж, жижиг, татварууд	847,660.00	
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	186,955,971.00	267,282,808.00
	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж урамшуулал		
	Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс		3,172,000.00
	Автомашин даатгал		518,340.00
	Улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн	186,355,771.00	262,978,868.00
	Тэтгэвэрт гарахад тэтгэмж		
	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	600,200.00	613,600.00
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	679,760,458.77	828,474,813.11
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	- 122,095,823.77	- 122,301,713.11
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО		
	Бараа материал худалдсаны олз		
	Үндсэн хөрөнгө худалдсны олз		
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ		
	Ханшийн зөрүүгийн гарз	-	-
	Хөрөнгө худалдсаны гарз		-
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	-
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	- 122,095,823.77	- 122,301,713.11

- 1,019,711,982.00

- -

- -

397,694,387.77 -
-

АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Тайлант үе: 2016/01/01 - 2016/12/31

Данс ны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	<u>ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН / 1 /</u>	<u>365,025,799.00</u>	<u>707,223,100.00</u>
	<u>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ӨӨРИЙН ОРЛОГО</u>	<u>-</u>	<u>184,239,500.00</u>
	Үндсэн үйл ажиллагаанаас санхүүжих		
	Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого		184,239,500.00
	Үнэ төлбөргүй хүлээн авсан		
	<u>ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</u>	<u>365,025,799.00</u>	<u>522,983,600.00</u>
	<u>Улсын төвлөрсөн төсвөөс</u>	<u>365,025,799.00</u>	<u>522,983,600.00</u>
	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	365,025,799.00	522,983,600.00
	<u>Нэмэлт санхүүжилтийн орлого</u>	<u>-</u>	<u>-</u>
	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд болсон нэмэлт орлого		
	Төсвийн урамшуулал		
	<u>Хандив тусламж</u>	<u>-</u>	<u>-</u>
	Хандив		
	<u>НИЙТ ЗАРЛАГА БА ЗЭЭЛИЙН ДҮН / 2 /</u>	<u>365,025,799.00</u>	<u>707,223,100.00</u>
	<u>УРСГАЛ ЗАРДАЛ</u>	<u>365,025,799.00</u>	<u>444,244,232.00</u>
	<u>Ажиллагчилтай холбогдсон зардал</u>	<u>282,066,070.00</u>	<u>315,456,239.00</u>
	<u>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</u>	<u>253,392,070.00</u>	<u>276,883,639.00</u>
	Үндсэн цалин	202,226,896.00	207,674,839.00
	Хоол унааны хөнгөлөлт	20,728,000.00	30,307,200.00
	Цалингийн тусгай нэмэгдлүүд	30,437,174.00	38,901,600.00
	Урамшуулал		
	<u>Ажил олгогчоос төлөх шимтгэл</u>	<u>28,674,000.00</u>	<u>38,572,600.00</u>
	<u>Бараа үйлчилгээний урсгал зардал</u>	<u>82,959,729.00</u>	<u>128,787,993.00</u>
	<u>Байр ашиглалттай холбоотой зардал</u>	<u>35,071,048.00</u>	<u>47,798,283.00</u>
	Гэрэл цахилгаан	24,889,048.00	43,639,283.00
	Түлш халаалт	4,836,000.00	
	Цэвэр бохир ус	5,346,000.00	4,159,000.00
	<u>Бусад бараа үйлчилгээний зардал</u>	<u>47,888,681.00</u>	<u>343,968,578.00</u>
	<u>Хангамж бараа материалын зардал</u>	<u>5,820,681.00</u>	<u>9,845,558.00</u>
	Бичиг хэрэг	1,434,900.00	2,976,500.00
	Тээвэр шатахуун	1,472,000.00	3,422,000.00
	Шуудан холбоо интернет	2,913,781.00	3,447,058.00
	Ном хэвлэл		
	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгч устгал, ариутгал		
	БҮТЭЗҮЙЛС		
	<u>Нормативт зардал</u>	<u>-</u>	<u>-</u>
	Эм,эмнэлгийн хэрэгсэл		
	Хоол,хүнс		
	Нормын хувцас		
	<u>Эд хогшил, урсгал засварын зардал</u>	<u>9,910,400.00</u>	<u>33,741,352.00</u>
	Багаж техник хэрэгсэл		
	Тавилга		
	Хөдөлмөр хамгаалалын хэрэгсэл		
	Жижиг эд хогшил худалдаа авах зардал		23,839,520.00
	Урсгал засвар	9,910,400.00	9,901,832.00
	<u>Томилолт зочины зардал</u>	<u>7,903,380.00</u>	<u>6,286,160.00</u>
	Дотоод томилолт	5,800,310.00	6,286,160.00
	Гадаад томилолт	2,103,070.00	
	<u>Бусдаар гүйцэтгүүлсэн АҮТХураамж</u>	<u>2,570,000.00</u>	<u>2,789,000.00</u>
	Аудит, зэрэглэл тогтоох үйлчилгээ	2,000,000.00	2,000,000.00

Даатгалын үйлчилгээ		
Мэдээлэл сурталчилгааны зардал		
Тээврийн хэрэгсэлийн оношилгоо		
Тээврийн хэрэгсэлийн татвар		
Газрын төлбөр		
Төлбөр хураамж болон бусад зардал		
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх		
Мэдээлэл технологийн үйлчилгээ		
Маягт хэвлүүлэх зардал	110,000.00	789,000.00
Харуул, хамгаалалтын зардал	460,000.00	
Бараа үйлчилгээний бусад зардал	21,084,020.00	27,714,040.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага		500,000.00
Байрны түрэссийн зардал	20,236,360.00	21,487,700.00
Бусад зардал	332,080.00	3,816,340.00
Төлбөр, хураамж, жижиг, татварууд	515,580.00	1,910,000.00
Бараа үйлчилгээний бусад зардал		
Ажил олгогчоос олгох тэтгэмж, шагнал	600,200.00	613,600.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал	600,200.00	613,600.00
Тэтгэвэрт гарахад тэтгэмж		
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		
<u>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</u>	<u>-</u>	<u>262,978,868.00</u>
Төвлөрүүлэх шилжүүлэг		262,978,868.00
Өглөг		
<u>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН</u>	365,025,799.00	707,223,100.00
<u>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ / 3=1-2 /</u>	<u>-</u>	<u>-</u>
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН / 5 /	-	-
Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ / 6=4-5 /	-	-
<u>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</u>	<u>-</u>	<u>-</u>
<u>Мөнгө эхний үлдэгдэл</u>		
<u>Мөнгө эцсийн үлдэгдэл</u>	<u>-</u>	<u>-</u>

-

-

-

_____ -

АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Тайлант үе: 2016/01/01 - 2016/12/31

/төгрөгөөр/

	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны дүн
	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,350,902,876.02	11,575,381.15	1,798,231,360.55	3,160,709,617.72
	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ				-
	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
	Тайлант үеийн үр дүн			- 121,058,323.77	- 121,058,323.77
					-
	<u>2015 оны 12-р сарын 31-нээр</u>	<u>1.350.902.876.02</u>	<u>11.575.381.15</u>	<u>1.677.173.036.78</u>	<u>3.039.651.293.95</u>
	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
	Дахин үнэлгээний нэмэгдэл				-
	Өглөг				-
	Өнгөрсөн үеийн үр дүн				-
	Тайлант үеийн үр дүн			- 122,301,713.11	- 122,301,713.11
	<u>2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</u>	<u>1.350.902.876.02</u>	<u>11.575.381.15</u>	<u>1.554.871.323.67</u>	<u>2.917.349.580.84</u>

-

-

АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Тайлант үе: 2016/01/01 - 2016/12/31

/төгрөгөөр/

Данс ны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	НИЙТ ОРЛОГЫН ДҮН	707,223,100	707,223,100	-	
	Төсвөөс урсгал санхүүжилт	522,983,600	522,983,600	-	
	Үндсэн үйл ажиллагааны орлогоос	184,239,500	184,239,500	-	
	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	522,983,600	444,244,232	78,739,368	85%
	УРСГАЛ ЗАРДАЛ	522,983,600	444,244,232	78,734,968	85%
	Ажиллагчилтай холбогдсон зардал	389,237,000	315,456,239	73,780,761	81%
	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	350,664,400	276,883,639	73,780,761	79%
	Үндсэн цалин	281,455,600	207,674,839	73,780,761	74%
	Нэмэгдэл	38,901,600	38,901,600	-	100%
	Хоол унааны хөнгөлөлт	30,307,200	30,307,200	-	100%
	Урамшуулал			-	
	Ажил олгогчоос төлөх шимтгэл	38,572,600	38,572,600	-	100%
	Тэтгэвэрийн даатгалын шимтгэл			-	
	Тэтгэмжийн даатгалын шимтгэл			-	
	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл			-	
	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл			-	
	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл			-	
	Бараа үйлчилгээний урсгал зардал	133,746,600	128,787,993	4,954,207	96%
	Байр ашиглалттай холбоотой зардал	47,815,400	47,798,283	17,117	100%
	Гэрэл цахилгаан	28,073,400	43,639,283	- 15,565,883	155%
	Түлш халаалт	16,624,000		16,624,000	0%
	Цэвэр бохир ус	3,118,000	4,159,000	- 1,041,000	133%
	Хангамж бараа материалын зардал	13,273,100	13,017,558	255,542	98%
	Бичиг хэрэг	2,976,500	2,976,500	-	100%
	Тээвэр шатахуун	3,422,500	3,422,000	500	100%
	Шуудан холбоо интернет	3,702,100	3,447,058	255,042	93%
	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгч устгал, ариутгал			-	
	БҮТЭЗүйлс	3,172,000	3,172,000	-	100%
	Нормативт зардал	-	-	-	
	Эм,эмнэлгийн хэрэгсэл	-	-	-	
	Хоол,хүнс	-	-	-	
	Нормын хувцас	-	-	-	
	Эд хогшил, урсгал засварын зардал	38,171,500	33,741,352	4,430,148	88%
	Багаж техник хэрэгсэл	23,839,520	23,839,520	-	100%
	Тавилга			-	
	Хөдөлмөр хамгаалалын хэрэгсэл			-	
	Урсгал засвар	14,331,980	9,901,832	4,430,148	69%
	Томилолт зочины зардал	6,303,900	6,286,160	17,740	100%
	Дотоод томилолт	6,303,900	6,286,160	17,740	100%
	Бусдаар гүйцэтгүүлсэн АҮ төлбөр	27,064,700	26,831,040	233,660	99%
	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21,487,700	21,487,700	233,660	100%
	Аудит, зэрэглэл тогтоох үйлчилгээ	2,000,000	2,000,000	-	100%
	Даатгалын үйлчилгээ	744,000	518,340	225,660	70%
	Мэдээлэл технологийн үйлчилгээ	1,650,000	1,642,000	8,000	100%
	Тээврийн хэрэгсэлийн оношилгоо	66,000	66,000	-	100%
	Тээврийн хэрэгсэлийн татвар	328,000	328,000	-	100%
	Газрын төлбөр			-	
	Төлбөр хураамж болон бусад зардал			-	
	Улсын мэдээллийг маягт хэвлэх, бэлтгэх	789,000	789,000		
	Бусад зардал			-	
	Бараа үйлчилгээний бусад зардал	500,000	500,000	-	100%
	Хичээл үйлдвэрлэлийн дадлага	500,000	500,000	-	
	Бараа үйлчилгээний бусад зардал			-	

<u>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</u>	618,000	613,600	<u>4,400</u>	
Нэг удаагийн тэтгэмж, шагнал	618,000	613,600	4,400	
Тэтгэвэрт гарахад тэтгэмж			-	
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-		-	
<u>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</u>	-	-	-	
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих			-	
Бусад орлого			-	
Төсвөөс санхүүжих			-	
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж			-	
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт			-	
<u>Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл</u>	-	-	-	
<u>Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл</u>				
Байгууллагын тоо				
Ажиллагчид бүгд	41	31	10	
Удирдах ажилтан	7	7	-	
Гүйцэтгэх ажилтан	34	24	10	
Үйлчлэх		-	-	
		-	-	
			-	
<u>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</u>			-	
Төвлөрүүлэх шилжүүлэг		262,978,868	- 262,978,868	
Өглөг			-	
<u>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ / 3=1-2 /</u>				
<u>Мөнгөн хөрөнгө 2016.12.31-ны үлдэгдэл</u>				
<u>Харилцахын үлдэгдэл</u>				
